



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өвөрхангай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ӨВА-2022/1/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Арвайхээр
2022 он

Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com

Аудитор: Э.Энхбаяр

Утас: 70323833 Цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Аудитын тайлан
- 3.1 Ерөнхий зүйл
- 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Материаллаг байдал
- 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....
- 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....
- 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг
- 3.8 Аудитын гол асуудал.....
- 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
4. Аудитын илрүүлэлт.....
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БӨЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв

1. Аудитын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

52173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/факс: (976) 7032 3253
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

Бодол 2022 № 211
танай _____ -ны № _____ -т

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ
ДЭМЖИХ САНГИЙН
ДАРГА Т.НАРАНГАРАВ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБООС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

015030422

D:\Auditin gazar\baiguullagin dotood barimt\A4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /төгрөгөөр/

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2422800628.00	2238007249.00
33	АВЛАГА	2422800628.00	2238007249.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	3537955.00	14497636.00
335	Бусад авлага	2419262673.00	2223509613.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2419262673.00	2223509613.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2422800628.00	2238007249.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2311 00628.00	2238007249.00
51	Засгийн газрын хувь оролцоо	231 500628.00	2238007249.00
512	Хуримтлагдсан үр дүн	2311500628.00	2238007249.00
51210	Өмнөх үеийн үр дүн	2216988535.00	2406942673.00
51220	Тайланг үеийн үр дүн	94512093.00	-168935424.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2311500628.00	2238007249.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	978735922.85	1063428266.74
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32458322.85	37603266.74
120	Нийтлэг татварын бус орлого	32458322.85	37603266.74
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2458322.85	37603266.74
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2458322.85	37603266.74
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	946277600.00	1025825000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	416955500.00	0.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	416955500.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	529322100.00	1025825000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан	0.00	10525000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	529322100.00	1015300000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	857291441.85	1232363690.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	857291441.85	1232363690.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5319000.00	6951400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1365000.00	5951400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1365000.00	5951400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3954000.00	1000000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	1000000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3954000.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	851972441.85	1225412290.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	418938466.00	266350650.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	418938466.00	266350650.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	32458322.85	33891585.74
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	32458322.85	33891585.74
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	15153941.00	6360000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	15153941.00	0.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	19291500.00	6360000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3: 5421712.00	918810055.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3: 5421712.00	918810055.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	121444481.00	-168935424.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	121444481.00	-168935424.00

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

АУДИТЛАГДСАН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,311,500,628	0.00	2,311,500,628
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	2,311,500,628	0.00	2,311,500,628
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0
C07	Тайлант үеийн үр дүн					0
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,311,500,628	0.00	2,311,500,628
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,311,500,628	0.00	2,311,500,628
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	95,442,045	0.00	95,442,045
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	2,406,942,673	0.00	2,406,942,673
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0	0.00	0
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0	0.00	0
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0	0.00	0
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0	0.00	0
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-168,935,424	0.00	-168,935,424
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,238,007,249	0.00	2,238,007,249

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1367695589.85	1063428266.74
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	421417989.85	37603266.74
120	Нийтлэг татварын бус орлого	421417989.85	37603266.74
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	421417989.85	37603266.74
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3885 9667.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	324 8322.85	37603266.74
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	946277600.00	1025825000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	416955500.00	0.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	416955500.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	529322100.00	1025825000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	10525000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	529322100.00	1015300000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1533454701.85	1679181326.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1533454701.85	1679181326.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5519000.00	6951400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1555000.00	5951400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15 35000.00	5951400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3954000.00	1000000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	1000000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3954000.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1527935701.85	1672229926.74
2132	Бусад урсгал шилжүүлэг	913438466.00	698670650.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	913438466.00	698670650.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	32458322.85	48389221.74
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	32458322.85	48389221.74
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	193079246.00	6360000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	387746.00	0.00
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	192691500.00	6360000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3885 9667.00	918810055.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3885 9667.00	918810055.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-165759112.00	-615753060.00
14	Бусад эх үүсвэр	0.00	615753060.00
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	0.00	615753060.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	615753060.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-165759112.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

АУДИТЛАГДСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН					
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	0.00	1025825000.00	705622050.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	0.00	1025825000.00	705622050.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	0.00	14525000.00	6951400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	0.00	0.00	13525000.00	5951400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	0.00	0.00	12025000.00	5951400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00	1000000.00	1000000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00	1000000.00	1000000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00	1011300000.00	698670650.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	0.00	1011300000.00	698670650.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	0.00	1011300000.00	698670650.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НТ-2

АУДИТЛАГДСАН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	705622050.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	705622050.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	6951400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	5951400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	5,951,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	1000000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	698670650.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	698670650.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	698,670,650.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	1025825000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	1025825000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	10,525,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,015,300,000.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Өвөрхангай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Энхбаяр нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Өвөрхангай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Аймгийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 24 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өвөрхангай аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээг иргэдэд чанартай, хүртээмжтэй, шуурхай хүргэх мэргэшсэн чадварлаг, ёс зүйг эрхэмлэсэн, бүтээлч хамт олон байх зорилготой Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн үйлчилгээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн үр дүнтэй зохион байгуулах, хэрэгжилтийг ханган ажиллах чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй байгууллага юм. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаар 2021 онд Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажилг агаг сэргээх хөтөлбөр, Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр хэрэгжүүлэхээр Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн тогтоол батлагдсан байна.

Тайлант хугацаанд тус байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бод тогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өвөрхангай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 1,232.4 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 12.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80.0 хувь буюу 9.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг санхүүгийн байдлын тайлангийн авлага хэсэгт орсон өөрчлөлтийн дагуу шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Санхүүгийн тайланд бараа материалын тодруулгыг бэлтгэжээ:

- Бараа материалын тодруулга тайлангаар 2021 онд бичиг хэргийн материал 10.9 сая төгрөг, аж ахуйн материал 3.4 сая төгрөг, түлш, шатах тослох материал 4.3 сая төгрөг, бусад хангамжийн материал 0.09 сая төгрөгөөр нэмэгдэж нийт 18.8 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төслийг хуулийн хугацаанд бэлтгэж, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газарт нэгтгүүлж ирсэн байна. 2021 оны төсвийн төсөлд ХЭД төв сангийн санхүүжилтээр 1,903.2 сая төгрөг, ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого 10.0 сая төгрөг, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 420.0 сая төгрөгөөр төлөвлөсөн ба ХЭД дэд сангийн тухайн оны санхүүжилтээр 853.3 сая төгрөг, 2020 оны өр барагдуулах санхүүж илтээр 111.3 сая төгрөг, ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого 10.0 сая төгрөгөөр тус тус батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого 37.6 сая төгрөг, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 615.8 сая төгрөгийн орлого орсон ба гүйцэтгэлээр нийт 653.4 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, үүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд ХЭД төв сангаас 904.0 сая төгрөг, 2020 оны өр барагдуулах санхүүжилт 111.3 сая төгрөг, Дэлхийн банкны санхүүжилтээр хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийн хүрээнд 10.5 сая төгрөгийн санхүүжилт авсан ба тайлант оны нийт төсвийн гүйцэтгэл 705.6 сая төгрөг, төвлөрүүлэх шилжүүлгээр 320.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаа бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим, сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэхэд зөрчил илрээгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Өвөрхангай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь шилэн дансны цахим хуудсанд нийт 150 мэдээлэл байршуулахаас 125 мэдээллийг хугацаанд нь, 24 мэдээллийг хугацаа хоцроосон, 1 мэдээлэл байршуулах хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол зэрэг бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сори ид үндэслэн шалгасан зүйлсийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэсэн болно.

3.10 Өмнөх албан шаардлагын хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 6.5 сая төгрөгөөр программ хангамж худалдан авч байгууллагын хөрөнгөд бүртгээгүй зөрчил илэрч албан шаардлага өгсөн бөгөөд биелэлтийг 2021 оны 05 сарын 20-ны өдрийн 185 тоот албан бичгээр ирүүлсэн.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллийг тогтоосон хугацаанд бүрэн байршуулсан эсэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитын явцад эрсдэлд суурилж горим сорил хэрэгжүүлэхэд алдаа зөрчил илрээгүй.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулга хийгдээгүй.

4.2 Төлбөрийн акт

Акт тавигдаагүй.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

4.4 Зөвлөмж

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байх чиглэлээр зөвлөмж өгөгдсөн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс								
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	1									1	
	Нийт	1									1	

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН: АУДИТОР

Э.Энхбаяр

